

**АЛС ДОРНОДЫН ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН НЭГ ЧУХАЛ АСУУДАЛ****Б. Батболд**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

АНУ-ын өнөөгийн засаг захиргааны болон империалист хүчний дайнч, түрэмгий бодлогын уршгаар олон улсын байдал хурцадмал шинжтэй болж байгаа билээ. Ялангуяа АНУ-ын эрх баригчид ердийн болоод цөмийн зэвсгээр улайран хөөцөлдөж цэрэг, зэвсгийн давуутай талыг зөвхөн өөртөө буй болгон олон улсын харилцаанд хүчээр түрий барин жанжлах балмад бодлогыг хэрэгжүүлэхээр санаархаж байна. Тэгээд ч манай гаригийн газар сайгүй, өнцөг булан бүхэнд АНУ-ын ашиг сонирхлын бүс байгаа тухай эрээ цээрээгүй зарлаж байгаа юм.

АНУ болон НАТО-гийн эрх баригчид Баруун Европт америкийн дунд зайны тусгалтай пуужингаа байрлуулж эхэлснийхээ дараагаар Ази тив, ялангуяа Алс Дорнодод гол анхаарлаа хандуулах боллоо. АНУ-ын Батлан хамгаалах яамны сайд Г. Уайнбергерийн мэдэгдснээр Алс Дорнод нь «Европын дараа орж байгаа америкийн амин чухал ашиг сонирхлын бүс»<sup>1</sup> болж байгаа ажээ. АНУ-ын өнөөгийн засаг захиргаа нь Ази-номхон далайн бүс нутгийг ЗХУ болон социалист бусад улс оронтой сөргөлдөх гол талбар гэж үзэж байгаа тухай гадаадын хэвлэл мэдээлж байна. Энэхүү асуудал нь өргөн хүрээтэй учир энэ өгүүлэлд зөвхөн Солонгосын хойгийн орчин тойрныг авч үзэв. Тус бүс нутагт АНУ-ын үлэмж хэмжээний цэрэг, зэвсгийн бүлэглэл (Алс Дорнодод АНУ-ын цэргийн 300 гаруй бааз, объект) байрлаж байна.

Нэн ялангуяа Вашингтоноос Өмнөд Солонгосын хувьд баримталж байгаа бодлого нь Европ тивийн адилаар хоёр талтай нэгэн зорилт болж байна. Энэ нь холбоотнууддаа (Япон, Өмнөд Солонгос) цэрэг, улс төрийн шахалт дарамт үзүүлж тэдний нутаг дэвсгэрт стратегийн болон тактикийн пуужинг байрлуулан цөмийн мөргөлдөөн үүсэхэд хүрвэл түрүүлж цохилт өгөх буюу хариу цохилт хүлээх талбар болгон ашиглах зорилготой байгаа юм.

АНУ-ын хувьд Өмнөд Солонгос нь Японыг бодоход цэрэг зэвсгийн талаар илүү тохиромжтой түнш болж байна. Сөүлийн дэглэм удаа дараалан тагнуулын төв газар, Пентагоны дайнчдын адал балмад үүрэг даалгаврыг дуулгавартай биелүүлж ирснээс гадна 650 мянган хүний бүрэлдэхүүнтэй армитай байгаа нь Азийн өөр ямар ч хөрөнгөтөн орны армиас давуутай байгаа ажээ. Чон Ду Хваны дэглэм армийн хэрэг-

<sup>1</sup> «Нью-Йорк Таймс», 5.V.1981.

цээнд жил бүр 3,7 млрд доллар зарж байгаа нь улсын төсвийн 40 хувьд хүрчээ. Үүнээс гадна АНУ-ын эрх баригчид Сөүлийн дэглэмд үзүүлж байгаа цэргийн тусламжаа нэмэгдүүлсний зэрэгцээ орчин үеийн дайн байлдааны шинэхэн зэвсгийг нийлүүлж байна.

Вашингтоны цэргийн тусламж нь 1982 онд 166 сая доллар, 1983 онд 210 сая доллар, 1984 онд 232 сая долларт хүрч өсчээ. Түүнчлэн Өмнөд Солонгосын цэргийн зардлын зарим хэсгийг 1983 оны 1-р сараас эхлэн Япон улс хөнгөлттэй зээллэг өгөх журмаар төлөлцөж байгаа ажээ.

1983 оны 11-р сард АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейган Япон, Өмнөд Солонгост албан ёсны айлчлал хийсэн явдал америкийн өнөөгийн засаг захиргаанаас Токио, Сеулд ямар ач холбогдол өгч байгааг тодорхой харуулсан юм. Японы «Майнити» сонины бичсэнээр, Р. Рейган Өмнөд Солонгост байхдаа Солонгосын цэрэггүй бүсийн районд зориуд очиж зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг өдөөн хатгасан шинж бүхий үг хэлсэн явдал Солонгосын хойгийн өмнөд хэсгийг Алс Дорнод дахь АНУ-ын түрэмгийллийн цайз болгох гэсэн санаархалын тод илрэл болсон билээ.

1945 оны сүүлчээс эхлэн америкийн цэрэг Өмнөд Солонгост байрлаж эхэлсэн бөгөөд АНУ-ын түрүүчийн хэд хэдэн засаг захиргаа цэргүүдийнхээ тоог хорогдуулж байсан боловч Р. Рейганы үед эрс нэмэгдэж Өмнөд Солонгос дахь америкийн цэргийн тоо эдүгээ 41 мянга гаруй болжээ.<sup>2</sup> Вашингтон эдгээр цэргийн зардалд болон тэднийг шинээр зэвсэглэхэд зориулж үлэмж хэмжээний хөрөнгө мөнгө гаргаж байгаа бөгөөд зөвхөн 1982—1983 онд нэг миллиард гаруй доллар заржээ.<sup>3</sup>

Өмнөд Солонгосын нутаг дэвсгэрт Пентагон цэргийн томоохон 40 баазтай бөгөөд цэргийн бусад объектыг оролцуулбал нийтдээ 100 гаруй болох юм.

Өнөөгийн байдлаар Өмнөд Солонгос нь бүхэлдээ Америкийн цэргийн орчин үеийн томоохон бааз болсон бөгөөд тодруулж хэлбэл цөмийн зэвсгийн иж бүрэн бааз болжээ.

Солонгосын хойгийн өмнөд хэсэгт Пентагон 700—1000 нэгж цөмийн зэвсэг<sup>4</sup>, түүнчлэн уг зэвсгийг мянга гаруй км-ийн цаана зөөж чадах Ф—16 зэрэг байлдааны орчин үеийн онгоцуудыг байрлуулжээ. АНУ-ын эрх баригчид Өмнөд Солонгосын нутагт «Першинг-2» болон далавчит пуужин, нейтроны зэвсэг байрлуулах тухай төлөвлөгөө боловсруулж буйг нэг бус удаа гадаадын хэвлэлүүд мэдээлсэн билээ. Өмнөд Солонгосын тоглоомын засгийг ашиглан АНУ пуужин-цөмийн зэвсгээ Өмнөд Солонгост онцын саад бэрхшээлгүй байрлуулж байна.

Сүүлийн жилүүдэд АНУ-аас Алс Дорнодод явуулах цэрэг-улс төрийн бодлогын хүрээнд Япон улсыг улам бүр чухал үүрэг гүйцэтгүүлэх талаар америкийн эрх баригчид үлэмж хүч чармайлт гаргаж байгаа нь нийтэд тодорхой билээ.

Пентагон нь өөрийн цэргийн хамсаатан нартайгаа хамтран жил бүр «Тим спирит» гэдэг нууц нэртэй цэргийн томоохон хээрийн сургуулийг Алс Дорнодод тогтмол хийж байна. Цэргийн энэ хээрийн сур-

<sup>2</sup> «Нью - Йорк Таймс» 12.XI.1983.

<sup>3</sup> Международная жизнь, № 11, 1983. с. 143.

<sup>4</sup> Мөн тэнд.

<sup>5</sup> «Известия», 4.XI.1983.

гууль нь урт удаан хугацаагаар үргэлжилж байгаагаараа (хоёр сар гаруй) болон оролцож байгаа цэргийн тоогоороо (200 мянга гаруй хүн) төдийгүй цөмийн зэвсэг хэрэглэх нөхцөлд дайрч довтолж сургууль хийж байгаа шинж байдлаараа дэлхийн олон нийтийн анхаарал татаж байна.

Нэн ялангуяа «Тим спирит—84» нь Солонгосын асуудлыг хэлэлцээний үндсэн дээр тайван замаар шийдвэрлэх талаар АНУ, БНАСАУ, Өмнөд Солонгосын гурван талын уулзалт хийх тухай санал дэвшүүлсний дараагаар болсныг гадаадын хэвлэл онцлон тэмдэглэж байна.

Ийнхүү Солонгосын хойгийн хувьд баримталж байгаа АНУ-ын бодлого нь зөвхөн Ази төдийгүй дэлхийн дэвшилт хүн төрөлхтнийг түгшээж байгаа асуудлын нэг болов.

Олон улсын байдал хурцадмал байгаа өнөө үед Алс дорнод болон Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд ЗХУ болон Азийн социалист бусад улс орны дэвшүүлж байгаа энх тайванч санал санаачлагыг нухацтай авч үзэн хэрэгжүүлбэл тус бүсийн төдийгүй дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэхэд чухал хувь нэмэр болохсон билээ.

## **ВАЖНАЯ ПРОБЛЕМА МИРА И БЕЗОПАСНОСТИ НА ДАЛЬНЕМ ВОСТОКЕ**

### **(Р е з ю м е)**

Ход развития международной обстановки в последнее время с особой убедительностью подтверждает, насколько велика угроза человечеству со стороны империалистических и милитаристских кругов и насколько настоятельно необходимо мобилизовать и сплотить все политические и общественные силы мира, против опасности ядерной катастрофы.

Вместе с тем нельзя не видеть как США и их союзники астрономически увеличивают по плану темпы и масштабы своих военных при готовлений на Дальнем Востоке для того чтобы оказать давление на Советский Союз и другие социалистические страны. В этих своих аванторных действиях немаловажная роль отводится ими Корейскому полуострову.

В этой чрезвычайно опасной игре судьбами народов администрация США рассматривает Азиатско-Тихоокеанский регион, в частности Корейский полуостров как один из основных плацдармов непосредственной конфронтации с Советским Союзом и миром социализма. Политика Вашингтона в отношении Южной Кореи определяется его общей стратегической линией во всем Азиатско-Тихоокеанском регионе, т. е. линией нанести удар Советскому Союзу и миру социализма с востока в случае ядерного конфликта.

Автор статьи подчеркивает, что Южная Корея является важным континентальным звеном американо-японского военно-политического союза в случае трагического развития событий.

Таким образом стратегические планы США в отношении Корейского полуострова, как отмечает автор естественно, вызывают законную тревогу и озабоченность всех миролюбивых сил мира, стран Дальнего Востока в особенности.

В заключении автор выражает надежду, что справедливое решение корейской проблемы мирным демократическим путем явилось бы важным позитивным элементом оздоровления обстановки на Дальнем Востоке и во всем Азиатско-Тихоокеанском регионе.